

ТАНИЛЦУУЛГА

*“Итгэлцүүр батлах тухай” Засгийн газрын
тогтоолын төсөл боловсруулсан тухай*

2025 оны 07 дугаар сарын 29-ний өдөр

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэгт “Итгэлцүүрийг улсын дундаж цалин, хэрэглээний үнийн өөрчлөлттэй уялдуулан Үндэсний статистикийн хорооны саналыг үндэслэн Засгийн газар жил бүрийн 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор тогтоож, дараа жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөнө” гэж заасан.

Хуулийн дээрх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор даатгуулагчийн шимтгэл төлөх болон тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын өнөөгийн үнэ цэнийг тодорхойлоход хэрэглэх 2026 оны итгэлцүүрийг улсын дундаж цалин, хэрэглээний үнийн өөрчлөлттэй уялдуулан тооцож “Итгэлцүүр батлах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулсан.

Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхэд шаардлагатай 11.0 тэрбум төгрөгийг Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн саналд тусгасан болно.

Үзүүлэлт	2026 он					
	Шинээр тэтгэвэр тогтоолгох иргэдийн тоо	Итгэлцүүрээр өсөх тэтгэвэр авагчдын тоо	Өмнөх итгэлцүүрээр тооцсон дундаж тэтгэвэр /мян.төг/	Итгэлцүүрийн нөлөөлөл /мян.төг/	Шинэчилсэн итгэлцүүрээр тооцсон дундаж тэтгэвэр /мян.төг/	Нэмж шаардагдах хөрөнгө /сая.төг/
Өндөр насны	43,118	15,091	1,020.0	66.3	1,086.3	6,473.8
Тахир дутуугийн	17,465	6,113	725.9	47.2	773.1	1,866.1
Тэжээгчээ алдсаны	4,922	1,723	741.5	48.2	789.7	537.2
Цэргийн	2,246	2,246	1,929.1	125.4	2,054.5	1,821.8
Дүн	67,750	25,172	4,416.6	287.1	4,703.7	10,699.0
Тахир дутуугийн	398	398	1,268.2	82.4	1,350.6	212.3
Тэжээгчээ алдсаны	61	61	1,526.2	99.2	1,625.4	39.2
Дүн	459	459				251.4
Нийт	68,209	25,631	4,417	287	4,704	10,950.4

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ